



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл
ажиллагааны стратеги, зохион байгуулалтын
бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2017 оны “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 87 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны “Үндэсний итгэмжлэлийн төв байгуулах тухай” 270 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн дагуу албан хаагчдыг зөв зохистой байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний итгэмжлэлийн төв (Ц.Батдорж)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргилд даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2026 оны 79 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Н.НОМТОЙБАЯР

0026100597

Монгол Улсын Шадар сайдын
2026 оны 06 дугаар сарын 30-ны
өдрийн 029 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Үндэсний итгэмжлэлийн төв (цаашид "төв" гэх)-ийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцооны хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, дотоод хяналт хийх, үнэлгээ өгөх зэрэг асуудлыг хамарсан стратеги болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2.Үндэслэл

Энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3.Хууль, эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол;

- “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол;
- “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол;
- “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол;
- “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоол;
- “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол;
- “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол;
- Бусад хууль тогтоомж.

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох олон улсын стандарт, дэлхийн болон бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагууд болох Global AСI, APAC-ын зөвлөмж, олон улсын байгууллагуудын өөрчлөлтийн удирдлага, стратеги төлөвлөлт, бизнесийн үйл ажиллагааны дахин инженерчлэлийн арга зүй, түүнчлэн Засгийн газар, яам, агентлагуудын үйл ажиллагааны стратеги болон зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүдийг судлан ашиглав. Мөн тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо, тохирлын үнэлгээний байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой олон улсын хуримтлагдсан туршлага, нийтлэг зарчим, шилдэг жишгийг харгалзан үзэж тусгав.

1.5.Байгууллагын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь


Үндэсний итгэмжлэлийн төв нь Засгийн газрын үйл ажиллагааны тохирлын үнэлгээний итгэмжлэлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг, хариуцлага хүлээж, Монгол Улсын Шадар сайдад зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Төв нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд хууль тогтоомжийн хүрээнд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдаж зохицуулна.

Тус төв нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс болон бүс нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндсэн чиг үүргийнхээ хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг хамарсан Засгийн газрын зөвлөхийн үүрэг, хариуцлага хүлээнэ.

1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Үндэсний итгэмжлэлийн төвийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь төвийн үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах загварт оруулсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Үндэсний итгэмжлэлийн төвийн үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Монгол Улсын Шадар сайд, Шадар сайдын Ажлын алба байна. Төвийн стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Төвийн бодлого, зохицуулалтын үйлчлүүлэгч нь бусад яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, иргэд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчид, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага байна.

Үндэсний итгэмжлэлийн төвийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон тус төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болон Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Үндэсний итгэмжлэлийн төв нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана.Үүнд:

2.2.1.Худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон худалдааг хөнгөвчлөх олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, түүнийг хэрэгжүүлэх;

2.2.3.Дэлхийн болон бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (Global ACI, APAC)-ын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.4.Тохирлын үнэлгээний байгууллагууд (сорилт/шалгалт тохируулга, эмнэлгийн лаборатори, техникийн хяналт, бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын байгууллага)-ын үйл ажиллагаа нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын хүчин төгөлдөр стандарт, дэлхийн болон бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (Global ACI, APAC)-аас гаргасан шаардлагад нийцсэн эсэхэд үнэлгээ хийж, итгэмжлэл олгох замаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах.

2.3.Үйл ажиллагааны зарчим

Үндэсний итгэмжлэлийн төв нь үйл ажиллагаагаа олон улсын стандарт, бүс нутгийн болон дэлхийн итгэмжлэлийн байгууллагын холбогдох баримт бичигт нийцүүлэн хэрэгжүүлж, итгэмжлэлийн үйл ажиллагаанд шударга байдал, хараат бус байдал, бие даасан байдал, үл ялгаварлах зарчим, ил тод байдал, мэргэшсэн байх, хууль дээдлэх болон хариуцлагын зарчмыг баримтална. Үүнд:

2.3.1.Төв нь хараат бус байдлыг хангах, аливаа улс төр, захиргааны болон зах зээлийн нөлөөллөөс ангид байж, итгэмжлэлийн шийдвэрийг зөвхөн баримт нотолгоо, тогтоосон шалгуурын үндсэн дээр гаргана.

2.3.2.Шударга байдал, үл ялгаварлах зарчмыг баримталж, итгэмжлэлийн үйлчилгээ авч буй бүх тохирлын үнэлгээний байгууллагад өмчийн хэлбэр, хэмжээ, байршил болон бусад нөхцөл байдлаас үл хамааран ижил шаардлага, үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлнэ.

2.3.3. Чадамжид суурилсан итгэмжлэлийн үнэлгээ хийх үнэлгээний мэргэжилтэн, шинжээчид болон шийдвэр гаргагчид нь мэргэжлийн зохих боловсрол, сургалт, ур чадвар, туршлагыг хангасан байх ба тэдгээрийн чадамжийг тогтмол үнэлж баталгаажуулна.

2.3.4. Ил тод байдлыг хангах бөгөөд итгэмжлэлийн журам, шаардлага, үнэлгээний ерөнхий үйл явц нь тодорхой, хүртээмжтэй байх, байгууллагын нууц мэдээллийг хамгаалах зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд мэдээллийн нууцлалыг чанд хадгална.

2.3.5. Итгэмжлэлийн үйл ажиллагаанд тогтоосон бодлого, шаардлага, шалгуурыг жигд, тууштай хэрэгжүүлж, үнэлгээ болон шийдвэр гаргалтын нийцтэй байдлыг ханган, ижил нөхцөл байдалд ижил шийдвэр гаргана.

2.3.6. Үндэсний итгэмжлэлийн төв нь гаргасан бүх шийдвэр, үйл ажиллагааныхаа үр дагаврыг бүрэн хариуцаж, тогтолцооны итгэлцэл болон тасралтгүй сайжруулалтыг хангах үүрэгтэй байна.

2.4. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Үндэсний итгэмжлэлийн төвийн эрхэм зорилго нь Монгол Улсын хөгжлийн стратеги чиг хандлагад нийцүүлэн итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын үр дүнг олон улс, бүс нутаг, гадаад оронд хүлээн зөвшөөрүүлэх, худалдааг хөнгөвчлөх замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх, улс орны нийгэм, эдийн засгийг бэхжүүлэхэд оршино.

2.5. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үндэсний итгэмжлэлийн төв нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.5.1. Төвийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

2.5.2. Гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний хэмжээнд өргөжүүлэх;

2.5.3. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомж, бодлого, стратегийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт хийх, үнэлгээ, дүгнэлт өгөх;

2.5.4. Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, дэлхийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэх;

2.5.5. Олон улсын гэрээ, хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний тохирлын үнэлгээний байгууллагуудын итгэмжлэлийн талаарх мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх.

2.6.Үйл ажиллагааны гол зорилт

Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана.

2.6.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1.Төвийн захиргаа удирдлагын манлайллыг хангах, хөрөнгө санхүүгийн удирдлага, дотоод үйлчилгээгээр байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.6.1.2.Салбарын хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх;

2.6.1.3.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, хууль тогтоох байгууллагад уламжлах;

2.6.1.4.Үндэсний итгэмжлэлийн төвийн бодлого, стратегийг төлөвлөх, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;

2.6.1.5.Салбарын гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний хэмжээнд хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

2.6.1.6.Тохирлын үнэлгээний үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, мэдээлэх, үйлчилгээ үзүүлэх, сурталчлах;

2.6.1.7.Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах;

2.6.1.8.Салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх хүрээнд программ хангамж, техник хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

2.6.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдал, батлагдсан төсвийн зарцуулалт, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, аюулгүй байдлын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

2.6.2.2.Хууль тогтоомж, төвийн даргын шийдвэр, бодлого, хөтөлбөр, төсөл, гэрээний хэрэгжилтийн явц болон дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, үр дүнд үнэлгээ өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, байгууллагын даргыг зөвлөгөө, мэдээллээр хангах;

2.6.2.3.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод шалгалтыг хийх, байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хангуулах, тайлагнах;

2.6.3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын төсөл, үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилт зохицуулалтыг хангах;

2.6.3.2.Тохирлын үнэлгээний байгууллагын маргаан шийдвэрлэх комисс, техникийн хороодын үйл ажиллагааг зохицуулах, нийтлэг арга зүйгээр хангах;

2.6.3.3.Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудын нэгдсэн тогтолцоог бий болгох, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах;

2.6.3.4.Итгэмжлэлийн ажил, үйлчилгээний хүрээг олон улсын тогтолцооны дагуу өргөтгөх, чанарыг хангах; /Бүтээгдэхүүн, үйлчилгээ, удирдлагын тогтолцоо, ажилтны болон бусад баталгаажуулалтын байгууллага, техникийн хяналтын байгууллага, сорилт, шалгалт тохируулга, эрүүл мэндийн лабораторийг итгэмжлэх/;

2.6.3.5.Дэлхийн худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, хөнгөвчлөх зорилгоор хоёр талт болон олон талт хэлэлцээр (MRA)-т нэгдэн орох чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

2.6.3.6.Дэлхийн болон бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (Global ACI, APAC)-ын техникийн болон холбогдох хорооны ажилд тогтмол оролцох;

2.6.3.7.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцох боловсон хүчнийг бүртгэх, сургах, эрх олгох ажиллагааг удирдан зохион байгуулах.

2.7.Үйл ажиллагааны зорилт

Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагааны зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны зорилтыг захиргаа, удирдлагын нэгж тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.8.Үйл ажиллагааны стратеги

Үндэсний итгэмжлэлийн төвийн үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна.